



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтанширээ сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/07/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn</p> <p>Багийн ахлагч аудитор: Ш.Сувдаа Цахим хаяг: smaudit97@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: domogovi@audit.gov.mn

2022.02.05 № 14/202

танай _____ -ны № _____ -т

АЛТАНШИРЭЭ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.МӨНХ-ЕРТӨНЦ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ



This PC: D/2022 onii ajil/A4 toot

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	96.0	87.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	888.4	1,033.3
	Нийт хөрөнгийн дүн	984.5	1,120.6
	Нийт өр төлбөрийн дүн	0.1	0.1
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	984.4	1,120.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	984.5	1,120.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	484.2	742.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	473.8	605.2
	Үйл ажиллагааны үр дүн	10.4	137.2
	Үйл ажиллагааны бус үр дүн		(1.1)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	10.4	136.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	753.1	753.1
	Тайлант оны үр дүн	(599.9)	(463.1)
	Эцсийн үлдэгдэл	984.4	1,120.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	476.8	525.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	476.8	524.0
	Үйл ажиллагааны ЦМГ	-	1.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	1.1
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	520.6	518.8
	Урсгал зардал	520.6	518.8
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	520.6	518.8
	Улсын төсвөөс	132.6	130.9
	Орон нутгийн төсвөөс	387.9	387.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэндлэх хүндлэх ёсыг эрхэмлэсэн, эх хэл, түүх соёлоо дээдэлсэн, байгальд хайртай сурагч төлөвшүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дорноговь аймгийн Алтанширээ сумын ЕБС-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 136,1 сая төгрөгөөр буюу 12,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш зарлага бүхий 1 гүйлгээг хоцроосон, нийт 43 тушаал, шийдвэрээс 29 тушаалыг хугацаанд нь байршуулж, 3 тушаалыг огт байршуулаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ковид-19 цар тахалтай холбоотой дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүй хандив, тусламж хүлээн авч, зарцуулсан байх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 20.3 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 20.3 сая төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

1. Үр дүнгийн тайлангийн зардалд нэмэлт санхүүжилтийн данснаас төсөвт буцааж төвлөрүүлсэн 3640,4 мянган төгрөгийг тусгаагүй нь “НББ-ийн тухай хууль”-ийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим гэсэн 5 дугаар зүйлийн 6.1.4-т үнэн зөв байх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байсныг аудитын явцад залруулав.
2. Үр дүнгийн тайлангийн зардалд үндсэн хөрөнгийн гарз 1125,6 мянган төгрөгийг тусгаагүй нь “НББ-ийн тухай хууль”-ийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим гэсэн 5 дугаар зүйлийн 6.1.4-т үнэн зөв байх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байсныг аудитын явцад залруулав.
3. Мөнгөн хөрөнгийн тайлангийн зардал талд 1,176.0 мянган төгрөгийн худалдах зардлыг ХО-ын мөнгөн зардлын Хөрөнгийн зардалд холбогдох урсгал зардлыг бууруулж салгаж бичилт хийлгүй санхүүгийн тайланд тусгасныг аудитын явцад залруулав.
4. Үр дүнгийн тайланд цалин нэмэгдэл урамшууллын зардал дутуу олгосон зөрүүг хаасны авлагын үлдэгдэл 210.7 мянган төгрөгийг тусгаагүй үлдээсэн байсныг аудитын явцад залруулав.
5. Үндсэн хөрөнгийн үлдэх өртгийг 14,227.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг аудитын явцад залруулав.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	5	20.3	5	20.3	-	-				
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	5	20.3	5	20.3	-	-				